



Улс төрийн
Боловсролын
Академи



Монголын Нээлттэй
Нийгэм Хүрээлэн
(Соросын сан)

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ

Иргэдэд зориулсан гарын авлага

Зохиогчид:

Б.Алтансүх. УТБА-ийн багш, ЭША,
Магистр

Ё.Энхбаяр. УТБА-ийн багш, ЭША,
Магистр

Зөвлөхүүд:

Д.Лүндээжанцан. Хууль зүйн ухааны
доктор /Sc.D/, УТБА-ийн Удирдах
зөвлөлийн гишүүн, УИХ-ын гишүүн

Б.Дэлгэрмаа. УТБА-ийн Удирдах
зөвлөлийн гишүүн, хуульч

Улаанбаатар хот

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ

Агуулга

1. Иргэний амьдрал орон нутгийн төсөвтэй холбоотой юу?.....3-4
2. Орон нутгийн төсөв гэж юу вэ?.....4-10
3. Орон нутгийн төсөв хэрхэн боловсруулагдах вэ?.....10-14
4. Орон нутгийн төсөв хэрхэн хэлэлцэгдэн батлагддаг вэ?.....14-18
5. Орон нутгийн төсвийн зарцуулалтанд хэрхэн хяналт тавьдаг вэ?.....19-25
6. Орон нутгийн төсвийн үйл явцад иргэд хэрхэн оролцох вэ?.....25-29

Ялгах тэмдэг:

§ - Хуулийн заалт

• - Хүснэгт, схем

? - Шог зураг

£ - Нэр томъёоны тайлбар

ê - Жишээ

μ - Фото зураг

U - Зөвлөмж

1. ИРГЭНИЙ АМЬДРАЛ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТЭЙ ХОЛБООТОЙ ЮУ?

μ:1 ê:1

Намайг Донровын Өрнөх гэдэг. Уг нь Увс аймгийн уугуул боловч Төв аймгийн Эрдэнэ суманд суугуул болоод 20 гаруй жил болсон хүн. Хувиараа бизнес эрхэлдэг. Бизнес ч юу байхав дээ хувиараа алт олборлож байгаад саяхнаас албан ёсоор гар аргаар алт олборлодог аж ахуйн нэгж болсон юм. Үндэсний үйлдвэрлэлийн нэг мини хэлбэр гэж би өөрийн аж ахуйгаа нэрлэх дуртай.



Харин аж ахуйн нэгж болоод албан ёсоор үйлдвэрлэл эрхлээд эхлэхээр нэг асуудал босч ирдэг нь татварын асуудал юм байна. Хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл мэдээж төлнө. Дээр нь ашигт малтмалын ашиглалт явуулахад олгох тусгай зөвшөөрлийн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлдөг. Ингэхлээр л бидэнд ирэх цэвэр ашигт татварын ачаалал нөлөөлөх нь ойлгомжтой. Нэгэнт л над мэтийн бизнес эрхэлж буй хүмүүс татвар төлж байгаа болохоор тэр татвар нь хаана, юунд зарцуулагддаг, би төлсөн татварынхаа дүнд төрөөс, нийгмээс юу олж авах тухай өөрийн эрхгүй л сонирхоод ирэх юмаа. Ингээд би орон нутгийн төсвийн талаар сонирхон судлаж эхэлсэн.

За даа, төсвийн асуудал асар өргөн хүрээтэй, яг үнэндээ гэхэд мань мэтийн толгой хүрэхгүй асуудал юм шиг санагддаг байлаа. Миний төлсөн татвар бага ч гэлээ үр хүүхдийн минь сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сумын засаг захиргааны зардалд зарцуулагддаг гэдгийг урьд нь би мэддэг байсан ч тэгтлээ нэг их ухамсарлаж ойлгоод байдаггүй байжээ. Намайг ингээд ярихлаар та ч гэсэн нээрэн тийм шүү гэж бодох вий.

Одоо цагт ч бид бүхэн “Загасчны морь усгүй” гэгчээр өөртөө хамаатай олон асуудлуудыг өөртөө хамаагүй юм шигээр хандах болжээ. Магадгүй зарим нь төсөв мэтийн асуудлыг ярихлаар мань мэтэд хамаагүй гэх бий. Энэ чинь л бидний амьдралыг сайжруулахгүй байгаа гол шалтгаан юм. Иргэн бүр ухамсартайгаар нийгмийн асуудлуудад оролцоод санаа оноогоо хэлээд явдаг бол байдал арай өөр л болно доо. Юу юугүй сайжраад явчихгүй ч гэсэн “суусан цэцнээс явсан тэнэг дээр” гэдэг үг байдаг даа.

U:1

Ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлдэг алин ч бай тэднээс татвар авах нь тодорхой болохоор нэгэнт төлсөн татвараа юунд зарцуулагдаж байгааг мэддэг, хянадаг, санаа тавьдаг байх ёстой. Бид бүхэн хүүхдүүддээ мөнгө өгөөд юунд яаж зарцуулж байгааг нь асуудаггүй, болохгүй зүйлд зараад байвал учирлан хэлж санаа тавьдаггүй гэж үү дээ.

Түүнтэй адилаар татвар төлсөн бол тэр мөнгөнийхээ араас сонирхож байх л ёстой. Бидний төлсөн мөнгөөр төр засаг оршин тогтнож, төрөөс нийгэмд үзүүлэх үйлчилгээг явуулах санхүүгийн боломжтой болж байгаа билээ. Татварын ихэнхийг улсад төвлөрүүлэн татаад эргүүлэн хуваарилахдаа эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийг бий болгодог билээ.

Үнэндээ улсын болон орон нутгийн төсөв гэж байдаггүй байсан бол хэн ямар мөнгөөрөө үнэгүй түмний хүүхдийг сургаад, хэн зам засаад, хэн дэг журам, хууль сахиулаад байхав дээ. Энэ бүхнийг төр гэдэг бүхний эцэг хийгээд байх ёстой гэж ойлгох нь одоо үед тохирохгүй бодол юм. Төр гэдэг чинь үнэн хэрэг дээрээ миний татварын хөрөнгөөр үйл ажиллагаа явуулдаг миний байгууллага гэсэн үг. Төрд ажилладаг хүмүүс ч гэсэн татвар төлөгчид байхгүй бол өөрсдөө байхгүй гэдгээ ойлгох л хэрэгтэй. Тэд дээрээс удирдах гэхээсээ илүү бидэнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр надаас татвар аваад надад болон нийгэмд үйлчилдэг, зохицуулдаг тийм л тогтолцоо ардчилал юм. Тиймээс иргэн бүр улс орон, орон нутгийн асуудалд хамаатай, хэрвээ тэр бүхэнд оролцохгүй бол та өөрийнхөө эрх ашиг, сонирхлоо хамгаалж, хэрэгжүүлж, хөгжиж дэвшиж чадахгүй гэж би хэлэх байна.

Ингээд, та бүхэнтэй орон нутгийн төсвийн талаар мэдсэн сонссон зүйлээсээ хуваалцаж, бодол санаагаа солилцоё хэмээн зорьсон минь ийм учиртай юм. Эхлээд орон нутгийн төсөв гэж юу болох талаар ярилцаад, дараа нь түүний бий болох, батлагдах, хэрэгжих болон иргэд хэрхэн оролцож байгаа, хэрхэн оролцох ёстой талаар ярилцая.

2. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

?:1



Орон нутгийн төсөв гэхлээр ихэнх хүмүүст нөгөө орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүжилт гэж ойлгодог. Гэвч хэрэг дээрээ орон нутгийн төсөв гагцхүү орон нутгийн төсвийн байгууллагын ажилтнуудад биш харин орон нутгийн бүх иргэдэд хамаатай асуудал юм. Үүнийг тодруулах зорилгоор би та бүхэнд холбогдох хуулийн тодорхойлолтоос өгсүүлээд орон нутгийн төсвийн орлого, зарлага, орон нутгийн ямар албан тушаалтанд хандах зэрэг асуудлуудын талаар ярих болно.

£:1

Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсөв бол орон нутагт төрөөс иргэдэд үйлчлэхтэй холбоотой хөрөнгийг хэрхэн бий болгох, зарцуулах асуудлыг тусгасан хөтөлбөр

Нутгийн захиргааны байгууллага болон төсвийн байгууллагуудын орлого, зардлын тооцоог харуулсан санхүүгийн төлөвлөгөө

2.1

Та орон нутгийн төсвийн талаар хэнээс тодруулж болох вэ?

Орон нутгийн төсвийг Засаг дарга боловсруулж, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална.

Иймээс

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ

Засаг даргын тамгын газар

мэдээлэл өгөх үүрэг бүхий байгууллага юм. Ингээд би сумынхаа ИТХ-ын даргатайгаа уулзаж орон нутгийн төсвийн талаар асууж танилцав.

ê :2

Орон нутгийн төсвийн үйл явцыг *Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль /2002/, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай /2002/ хуулиар зохицуулдаг.*

Би тус сумын ИТХ-ын дарга Нямсүрэн



Нямсүрэн даргын зөвлөснөөр би Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуулиас орон нутгийн төсвийн тодорхойлолтыг¹ харлаа.

¹ *Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлээс ашиглав*

£ :1

Монгол улсын нэгдсэн төсөв

Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар бүрдүүлэн, зарцуулах төсвийг **улсын төсөв** гэнэ.



Улсын төсөв нь төрийн нийт үндэсний шинжтэй зардлуудыг (Боловсрол, Шинжлэх Ухааны зардал, батлан хамгаалах зэрэг) санхүүжүүлдэг.


Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах төсвийг **орон нутгийн төсөв** гэнэ.



Орон нутгийн төсөв нь тухайн бүс нутгийн иргэдэд төрийн зүгээс хүргэх үйлчилгээ, түүнтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлдэг.

Хэдийгээр улсын төсвийг дотор нь ийн хоёр хувааж байгаа ч энэ нь зарцуулалтын хэлбэрээсээ л хамаарсан нэг зүйлийн хоёр тал юм. Бие биенээс нь ялган салгаж ойлгож болохгүй.

Монгол улсын төсвийн багагүй хэсэг нь иргэдийн төлсөн татвараас бүрддэг тухай өмнө би ярьсан. Иймээс төсвийн хөрөнгийг хэрхэн бүрдүүлж, зарцуулж байгааг ил тод, нээлттэй, үнэн зөв иргэддээ тайлагнах ёстой. Нөгөө талаас иргэд төсвийн үйл явцад идэвхтэй оролцдог, хянадаг байх ёстой гэж хэлээд байгаа хэрэг.



2.2

Орон нутгийн төсөв хэрхэн бүрддэг вэ?

Төсвийн тухай хуулинд төсвийн бүрдэл хэсгүүдийг тодорхой заасан байдаг. Орон нутгийн төсвийн орлогыг аймаг, нийслэлийн ба сум, дүүргийн гэсэн хоёр хэсэгт хуваадаг байна¹. Та бүхэн доорхи хүснэгтээс юу ажиглаж болох вэ?


*Монгол улсын нэгдсэн
төсвийн тухай хуулийн 10
дугаар зүйлээс ашиглав.*

§ :2

	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг
Татварын орлого	<ul style="list-style-type: none"> F хотын албан татвар F ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр F газрын төлбөр F үл хөдлөх хөрөнгийн албан татвар F авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 	<ul style="list-style-type: none"> F бууны албан татвар F улсын тэмдэгтийн хураамж F агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж F ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох зөвшөөрлийн хураамж F байгалийн ургамал ашигласны төлбөр F ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр F түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр F ус, рашаан ашигласны төлбөр F орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар
Татварын бус орлого	<ul style="list-style-type: none"> F орон нутгийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг F орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого F улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт F хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт орох бусад орлого 	<ul style="list-style-type: none"> F орон нутгийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг F орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого F хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого

Орон нутгийн төсвийн орлогын түвшин болон татваруудын хувь хэмжээг тусгай хуулиудаар тогтоож өгдөг. Гэвч энэ татваруудын хувь хэмжээг чухам хэн тогтоох вэ?

ê :3



Эдгээрийг харьцуулахад Монгол улсад орон нутаг санхүүгийн хязгаарлагдмал эрх хэмжээтэй байдаг гэж манай сумын ИТХ-ын төлөөлөгчид үздэг нь ортой

ê :4




Аймаг, нийслэл хураахад хялбар татварын орлогыг нь өөртөө төвлөрүүлэн татаад сум, дүүргийн төсөвт хураахад төвөгтэй хэсгийг нь үлдээдэг.

Орон нутгийн татварын хувь хэмжээг УИХ-аас тогтоосон хэмжээнд иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтоодог гэх боловч хэрэг дээрээ ийм байдаггүй.

Эрдэнэ сумын ИТХ-ын дарга Нямсүрэн гуай болон бусад төлөөлөгчдийн ярьснаар орон нутгийн төсөв бол нутгийн захиргааны байгууллагууд өөрийн үүргийг ханган биелүүлэх, иргэдэд төрийн нэрийн өмнөөс бүх төрлийн үйлчилгээг хүргэх бололцоог хангаж байдаг үндсэн хэрэгсэл болдгийн хувьд дор дурдсан зарчмуудыг¹ мөрдлөг болгон ажилладаг юм байна.

¹ *Б.Баттүвшин*
“Нутгийн удирдлагын
практик асуудалд”,
УБ., 1999 он.

§ :3



2.3

Орон нутгийн төсөв юунд зарцуулагдах вэ?

Орон нутгийн төсвийг тухайн шатны Засаг дарга захиран зарцуулах эрх эдэлдэг. Улсын болон орон нутгийн төсвийн зарлагын талаар нэгдсэн төсвийн тухай болон төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиас харж болох бөгөөд харин орон нутгийн төсвийн зардлыг аймаг, нийслэлийн төсвийн зардал болон сум, дүүргийн зардал гэж ялган үздэг. Үүнийг дараах хүснэгтээс тодорхой харж болно¹.

¹ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн 51, 52, 53 дугаар зүйлээс ашиглав.

• :4§ :3

	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг
Зарлага	<ul style="list-style-type: none">§ Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зардал§ Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, геологи хайгуулын орон нутгийн шинж чанартай арга хэмжээний зардал§ Боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүл мэнд, биеийн тамирын байгууллагын зардал§ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн орон нутгийн удирдлагын зардал§ бусад зардал	<ul style="list-style-type: none">§ Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зардал§ Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх сум, дүүргийн шинж чанартай арга хэмжээний зардал§ Аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр тогтоосноос бусад нийгэм, соёлын байгууллагын зардал§ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зардал§ Бусад зардал

U :2


н Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 17-р зүйлд иргэн “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан тул орон нутгийнхаа Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгчид, Төрийн сангийн төсвийн мэргэжилтэн нараас тодорхой асууж лавлаж болно. Мөн эдгээр байгууллага, албан тушаалтнуудаас төсвийн талаар мэдээлэл хийхийг шаардаж байх хэрэгтэй. Үүнд урьд оны төсвийн гүйцэтгэл, ирэх оны төсвийн төслийн тайлан, Засаг даргын хэтийн болон богино хугацааны зорилтуудын төсөвтэй уялдах байдал гэх мэт багтах ёстой.

н Орон нутгийн төсвийн орлого зарлага болон бусад асуудлын талаар орон нутгийнхаа ИТХ-ын тогтоол, Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн мэдээлэл зэргээс нарийвчлан тодорхой мэдэж болно.

n Орон нутгийн төсвийн талаар Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 50-59 дугаар зүйлүүдэд байгаа тул тодруулан хараарай.

3. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ ХЭРХЭН БОЛОВСРОГДОХ ВЭ?

? :2



Орон нутгийн төсвийн талаар та бүхэн ойлголттой болсон учраас одоо төсвийн төслийг боловсруулах үе шатын талаар авч үзье. Орон нутгийн төсвийг тухайн шатны Засаг дарга нар захиран зарцуулах эрхтэй байдаг тул түүнийг боловсруулах буюу хэлэлцэн батлуулахад бэлтгэх үүрэг хүлээсэн байдаг. Энэ тухай Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасан байдаг.

§ :4

51.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй;

51.1.2 Төсвийн төсөл зохиох

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиас

£ :3 § :5


4.1.6 Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг зохиоход Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлж Улсын Их Хурлаас зөвшөөрсөн баримт бичгийг хэлнэ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиас

Төсвийн төслийг хийхдээ хуулинд заасан хугацаанд улсын төсвийн байгууллагууд, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбоотой ажиллаж саналуудыг авч нэгтгэнэ. Энэ талаар та бүхэн доорхи схемээс тодорхой харж болно. ¹

¹ *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн зарим заалтуудыг ашиглав.*

• :5 § :6



Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт Төрийн сангийн хэлтэс буюу төсвийн асуудал эрхэлсэн ажилтнууд байх бөгөөд холбогдох судалгаа тооцоог тэд хийдэг юм билээ. Манай сумын хувьд төсвийн туслах нягтлан нь Амаржаргал гэдэг залуухан эмэгтэй бий.

Засаг даргаас ИТХ-ын гишүүдэд хүргүүлэх орон нутгийн төсвийн төлөвлөгөөний төсөл ямар хэлбэртэй боловсрогддог болохыг тоймлон үзүүлье. Энэ төслийн хүснэгтийг би хэд хэдэн сум, дүүргийн төсвийн төслөөс харж байж хийсэн юм.

• :6 ê :5

..... /аймаг, нийслэл, сум, дүүргийн/ 2003 оны төсвийн төлөвлөгөөний төсөл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засаг даргын тамгын газар			байгууллага			
	Батлагдсан төсөв	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл	2003 оны төсөв	ИТХ хянасан	Батлагдсан төсөв	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл	2003 оны төсөв	ИТХ хянасан
Урсгал зардлын дүн	140253.6	168842.0	142025.8		9346.0	8349.9	7550.0	
Цалин хэлс	49310.0	49365.0	49500.0		4220.0	4194.1	4200.0	
НД шимтгэл	13291.6	13291.6	13500.0		1146.0	916.7	1150.0	
Бичиг хэрэг	9000.0	16037.4	15000.0		200.0	180.0	200.0	
Гэрэл, цахилгаан	467.0	600.0	500.0		150.0	138.3	100.0	
Түлш, халаалт	9404.0	15956.1	7475.8					
Тээвэр, шатахуун	3120.0	3350.0	3100.0		400.0	375.2	400.0	
Шуудан холбоо	5616.0	9177.0	5000.0		130.0	297.9	200.0	
Цэвэр, бохир ус	560.0	619.2	560.0					
Албан томилолт	600.0	1169.3	600.0		1300.0	1042.0	1000.0	
Ном хэвлэл	390.0	408.0	390.0		50.0	63.1	100.0	
Хичээл практик					300.0	150.0		
Эд хогшил авах	2550.0	2410.0	500.0		1000.0	587.0		
Нормын хувь, зөөлөн эд					50.0		100.0	
Хүнс хоол								
Эм								
Байрны түрээс								
Урсгал засвар	500.0	4249.7	1500.0			195.0		
Татвар хураамж	370.0	734.0	400.0					
Биеийн тамир								
Гадаад томилолт	2000.0	5774.3	4000.0					
Тэтгэмж урамшуулал	2875.0	5388.4	3000.0		100.0	210.0	100.0	
Гудамжны гэрэлтүүлэг								
Оюутны тэтгэмж	3700.0	982.8			300.0			
Хэлмэгсдийн зардал								
Халамжийн үйлчилгээ								
Ядуурлыг бууруулах зөвлөлийн сан	2000.0	2000.0	2000.0					
Нөөц хөрөнгө	34500.0	37328.1	35000.0					
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан								
Өөрийн орлого	1500.0	2000.0	458.0		1000.0	1014.5	1200.0	
ЭМД-ийн орлого								
Төсвийн татаас	138753.6	166842.0	141567.8		8346.0	7335.4	6350.0	
Нийт ажиллагсад	51				7		9	
Үүнээс удирдах	12		12		1		1	

Төрийн сангийн дарга...../...../

Төсвийн мэргэжилтэн...../...../

Эндээс та бүхэн юу анзаарч байна. Миний л хувьд ийм маягийн төсөвтэй сум байлаа гэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь бусад байгууллагуудаасаа илүү санхүүжилттэй хэдий ч бүтээн байгуулалт болон улсын хэмжээнд хэрэгжиж буй янз бүрийн хөтөлбөрүүдтэй холбоотой зардал, байгууллагуудын үндсэн хөрөнгө худалдан авах зардал зэрэг нь төсөвт огтоос суудаггүй зэрэг нь харагдаж байна. Мөн манай сумын ИТХ–ын төлөөлөгчид төсөвт орон нутгаас хийх ажлын зардлыг төсөвлөж өгөх, төсвийн орлогыг давуулан биелүүлсэн тохиолдолд захиран зарцуулах эрхийг нь орон нутагт олгох хэрэгтэй гэж ярьж байсныг санах юм.

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах ажлыг улсын төсвийг боловсруулах, батлахтай нэгтгэн тайлбарлах нь илүү ойлгомжтой болох юм. Учир нь улсын төсөв боловсрогдох, орон нутгийн төсөв боловсрогдох хоёр нь харилцан биенээсээ хамааралтай байдаг.

• :7

УИХ-аас дараа жилийн улсын төсвийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу хэлэлцэн баталж хууль гаргана. Уг хууль нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн санхүүжилтийн хэмжээг зааж өгнө.



УИХ-иас гарсан хуулийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нар орон нутгийн төсвийн төслийг боловсруулж аймаг, нийслэлийн ИТХ-д өргөн барина.

Аймаг, нийслэлийн ИТХ төсвийн төслийг хэлэлцэн батлаад сум, дүүргийн төсвийн санхүүжилтийн хэмжээг тогтоосон тогтоол гаргана.



Сум, дүүргийн ИТХ төсвийн төслийг хэлэлцэн батална.

Сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн төсвийн хүрээнд өөрийн төсөвт байгууллагуудын ирүүлсэн төсвийн төслийг үндэслэн төсвийн төслийг боловсруулан сум, дүүргийн ИТХ-д өргөн барина.



Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд төсвийн төслийг хүргэснээр орон нутгийн төсөв зохиох шат төгсгөл болдог байна.

U :3

п Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад иргэдийн санаа бодлыг тусгах эрх зүйн боломж одоогоор хомс байна. Иймээс та бүхэн Засаг даргынхаа үйл ажиллагааны хөтөлбөр болон үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө зэргийг сайтар судлан үзэх хэрэгтэй. Учир нь Засаг даргаас боловсруулдаг төсвийн төсөлд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулинд зааснаар дараахь асуудлууд багтан ордог байна. Үүнд:

w орон нутгийн удирдлагын богино болон дунд хугацааны зорилтууд;

w худалдан авах бүтээгдэхүүний анги, нийлүүлэх байгууллага, худалдан авах зардал;

w хөрөнгө оруулалтын төлөвлөгөө;

w эд хөрөнгө, санхүүгийн болон хүний нөөцийн ашиглалт зэрэг өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зорилтууд;

w жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй боловсруулсан дараа жилийн төсөвлөсөн санхүүгийн тайлан;

w Засаг даргын худалдаж авах бүтээгдэхүүний анги нь хэтийн зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа тухай тайлбар;

w өмнөх жилийн төсөв болон төсвийн гүйцэтгэлийг харьцуулсан дүн эдгээр болно.

п Мөн та Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг сайтар судлах хэрэгтэй.

п ИТХ-ын гишүүнээрээ дамжуулан өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлийг хянаж, дараа жилийн төсвийн төслийн явцыг байнга сонирхож байх хэрэгтэй.

4. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ ХЭРХЭН ХЭЛЭЛЦЭГДЭН БАТЛАГДАХ ВЭ?

μ :2 ê :6



Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэлийн ба сум, дүүргийн гэсэн үндсэн хоёр хэсэгтэй тухай бид урьд авч үзсэн бөгөөд энэ хоёр шатны төсөв нь тус бүртээ хэлэлцэгдэн батлагдана. Орон нутгийн төсвийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ хэлэлцэн батлах эрхтэй байдаг.

Энэ зураг дээр манай сумын ИТХ-ын төлөөлөгчид сумынхаа төсвийг хэлэлцэж байгаа нь харагдаж байна.

§ :7

50.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутаг дахь төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараахь бүрэн эрхтэй:

50.1.2 тухайн жилийн орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг хянах

*Төсвийн байгууллагын
удирдлага, санхүүжилтийн
тухай хуулиас*

Бодит байдал дээр аймаг, нийслэлийн төсвийн төсөл эхлээд хэлэлцэгдэн батлагдсаны дараа сум, дүүргийн төсвийн төсөл хэлэлцэгдэн батлагдах дараалалтай байгаа юм. Энэ нь улсын төсвөөс аймаг, нийслэл, цаашилбал аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөв шууд хамааралтай байдагтай холбоотой юм.

4.1

Аймаг, нийслэлийн төсвийн төсөл хэлэлцэгдэн батлагдах нь:

§ :8

Аймаг, нийслэлийн Засаг дарга төсвийн төслийг 12 сарын 01-ний өдрийн дотор боловсруулж ИТХ-д өргөн барина

Тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын өргөн барьсан төсвийн төслийг 1 сарын дотор хэлэлцэн батална.

Аймаг, нийслэлийн төсвийг баталснаас хойш 7 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

?:3


Аймаг, нийслэлийн Засаг даргын боловсруулсан төслийг ИТХ хэлэлцэхэд үед өөрийн саналаа оруулах зорилгоор байгууллагын төсвийн ерөнхий менежерүүд оролцож байлаа. Харин төсвийн байгууллагын шинэчлэлээс хойш бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээр асуудал зохицуулагддаг болсон тул ИТХ-ын хуралдаан дээр байгууллагын менежерүүд оролцох шаардлагагүй болсон юм.

ê:7



Иргэдийн Хурлын Төлөөлөгчид бид улсын төсөвт тусгагдаагүй зардлыг орон нутгийн төсөвт тусгах ямар ч эрхгүй л дээ. Тиймээс бүсээ чангалах л хэрэгтэй.

Эцэст нь ИТХ-ын тогтоол гарч төсвийн төсөл батлагдана. Уг тогтоол дээр ИТХ-ын дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Энэ тогтоол нь дараах хэлбэртэй байдаг.



**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

Улаанбаатар

Утас: _____

Факс: _____

Гурав. Дүүргийн төсөөс Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 413168.7 мянган төгрөгөөр тогтоосугай.

Дөрөв. Дүүргийн Засаг даргаас Нийслэлийн Засаг даргатай гэрээ байуулан санхүүжүүлэх зардлыг доор дурьдсанаар зөв шөврсүгэй.

	/мянган төгрөгөөр/
Зардлын нийт дүн	4031003.2
Үүнд:	
1. Боловсролын салбарт	3188227.0
2. Эрүүл мэндийн салбарт	814414.9
3. Нийгмийн халамжийн салбарт	28351.3

Тав. Дүүргийн Засаг дарга / /-г даалгах нь:

1. Дүүргийн төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл болон төрийн сангийн нэгдсэн дансны тогтоолоор хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулан дүүргийн төсвийн орлого, зарлагын тэнцлийг хангаж ажиллах
2. Дүүргийн санхүүгийн менежментийг сайжруулж, төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсөвт зардлыг үр ашгтай зарцуулахад тавих хангалтыг сайжруулж үр дүнг тооцож улирал тутам мөдэлж ажиллах

Дүүргийн 200... оны төсвийн төслийг батлах тухай

Монгол улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11-р зүйлийн 1-ийн 1, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5-р зүйлийн 1-ийн 2, 3, 52-р зүйлийн 1-ийн 2 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 10-р зүйлийг үндэслэн Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Наг. Дүүргийн оны орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээг доор дурьдсанаар баталсугай.

	/мянган төгрөгөөр/
1.1 Дүүргийн төсвийн нийт орлого	798510.0
1.1.1 Албан та тварын орлого	313510.0
1.1.1.1 а Орлогыг тухай бүр тө дорхойлох боломжгүй иргэдийн орлогын албан та твар	175000.0
1.1.1.1.16 Хувьчараа хөдөл мөр эрхэлсний орлого	135000.0
1.1.1 в Бууны албан та твар	3510.0
1.1.2 Бусад татварын орлого	90000.0
1.1.1 а Утасан тө мөрдгийн кураамж	35000.0
1.1.3 татварын бус орлого	10000.0
1.1.3 а Төсөвт байгууллагын өөрийн орлого	330000.0
1.1.3 б Хүү тогтруулийн орлого	15000.0
1.1.3 в Амьтлагддаггүй бусад орлого	40000.0
1.1.4 Хөрөнгийн орлого	413168.7
1.2 Нийслэлийн төсөвт шилжүүлэх орлого	413168.7

Хойр. Дүүргийн төсвийн оны зарлагын нийт дүн, нэр төрлийн хэмжээг доор дурьдсанаар баталсугай.

	/мянган төгрөгөөр/
2.1 Дүүргийн төсвийн нийт зарлага	385341.3
2.1.1 Цалингийн сан	106356.7
2.1.3 Засаг даргын нөөц сан	35000.0
2.1.4 Тохимж туйлчилгааны дүн	30800.0
2.1.5 Баруу үйлчилгээний бусад зардал	163987.6

ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


Аймаг, нийслэлийн төсвийг хэлэлцэн баталсны дараа сум, дүүргийн төсвийг хэлэлцэн батлах ажил эхэлнэ.

4.2

Сум, дүүргийн төсвийн төсөл хэлэлцэгдэн батлагдах нь:


Аймаг, нийслэлийн ИТХ төсвөө баталснаар сум, дүүргийн төсөв ерөнхий байдлаараа тодорхой болно. Сум, дүүргийн төсвийн төсөл батлагдах үе шатыг дараахь байдлаар үзүүлж болно.

• :10



• :11§ :9

Аймаг, нийслэл, сум дүүргийн төсөв болон улсын төсвийн батлагдах харилцааг дээрээс доош шатлалтай гэж болох юм.



34 дүгээр зүйл Санхүүгийн жил

34.1 Санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31/ний өдөр дуусгавар болно.


*Төсвийн байгууллагын удирдлага,
санхүүжилтийн тухай хуулиас*

Төсвийн хэлэлцэн батлах үйл явц бүхэлдээ тодорхой “дээд шатны төсвөөс” баталсан санхүүжилтийн хэмжээнд баригдаж, “дээд шатны төсвийн” хүрээнд хэрхэн хуваарилалт хийх вэ? гэдэг дээр л голлон анхаарал төвлөрч байна. Иймд хэрэг дээрээ хуваарилалтын хэлэлцүүлэг болдог байна.

U:4

- § Орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахад иргэд ИТХ-ын гишүүдээрээ дамжуулан оролцох эрхтэй. Эсвэл байгууллагын дарга нараар дамжуулан оролцох боломжтой. Учир нь ИТХ-ын төлөөлөгч бол таны хүсэл эрмэлзлэлийг орон нутагт төлөөлж буй орон нутгийн улс төрч тул таны эрх ашгийг хамгаалах, хангах үүрэгтэй. Харин төсвийн байгууллагын дарга нар буюу ерөнхий менежерүүд нь тухайн байгууллагыг өдөр тутмын удирдлагаар хангах тул таны амьдралтай холбоотой.
- § ИТХ-ын хуралдаанд иргэд биечлэн ажиглагчаар суух хэрэгтэй. Энэ талаар тухайн шатны ИТХ-ын хуралдааны дэг бүрт ялгаатай байдлаар заасан байгаа. Хэрвээ тухайлан заагаагүй бол хориглоогүй буюу оролцох байдал нээлттэй гэж үзэж болно. Хуралдаанд биечлэн суух нь асуудлыг сайтар нягтлах боломж олгоно.
- § Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулинд “Тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг 1 сарын дотор хэлэлцэн батална” хэмээн хугацааг нь зааснаас өөр тодорхой заалт байхгүй байна. Энэ нь төсвийн төслийг хэлэлцэх, батлахад иргэд хэрхэн оролцох талаар хуульчилсан зохицуулалт байхгүйг харуулна. Иймээс төсвийн төслийг олон нийтээр хэлэлцүүлдэг болгохын төлөө иргэд идэвхитэй ажиллаж нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад хүчтэй нөлөөлж байх нь зүйтэй юм. Хуулийн хориглосон заалт байхгүй тул Засаг даргын болон ИТХ-ын төсвийн боловсруулах, хэлэлцэх үйл явцад иргэдийг оролцуулах тухай журам бий болгож болох юм.

5. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАНД ХЭРХЭН ХЯНАЛТ ТАВЬДАГ ВЭ?



Бид өмнөх бүлгүүдэд орон нутгийн төсвийг боловсруулан батлах болон хэрэгжүүлэх үйл явцтай танилцсан бол одоо төсвийн хяналтын тухай авч үзье. Миний ойлгосноор хяналт бол зөвхөн шалгах, гүйцэтгэлийг харьцуулах бус бидний урд авч үзсэн төсвийн үйл явцын үргэлжлэл үе шат байх ёстой.


5.1

Орон нутгийн төсөвт хэн хяналт тавих вэ?

Төсвийн өдөр тутмын хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч буюу тухайн шатны Засаг дарга, мөн ИТХ хэрэгжүүлдэг. Харин хөндлөнгийн буюу гадаад хяналтыг төсвийн жилд доод тал нь нэг удаа Төрийн Аудитийн Алба¹ хийдэг.

¹ Төрийн Аудитийн Алба нь Монгол улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүд шалгалт хийн, дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөх үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага юм.

Төсвийн хяналтын хэлбэрүүд



Гэвч бодит байдал дээр хяналтын эхний хоёр хэлбэр тодорхой түвшинд хуульчлагдсан бол олон нийтийн хяналтын эрх зүйн үндэс маш тодорхой бус, түүнийг хэрэгжүүлэх боломж үндсэндээ баталгаажуагүй байгаа юм. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн дагуу орон нутгийн төсвийг дараах байдлаар албан ёсоор тайлагнах ёстой ажээ.¹

¹ Б.Намхайжанцан “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл” УБ., 2003. номноос ашиглав.

• :13 § :11

Жилийн эцсийн тайлан гаргах

Засаг дарга Аудитийн дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор ИТХ, СЭЗЯаманд хүргүүлнэ. [59.3]

Засаг дарга Төсвийн төслөө 12-р сарын 1-ний өмнө ИТХ-д оруулна. [58.1]

Санхүүгийн тайланг баталгаажуулна.

ТАТБ аудит хийж, дүгнэлтийг тайлан авснаас хойш 1 сарын дотор гаргана. [38.2]



ИТХ төсвийн төслийг хээлэлцэнэ. [58.3]

Засаг даргаас хүлээн авснаас хойш нэг сарын дотор хээлэлцэн батална.

Жилийн тайлан гаргана.

Засаг дарга жилийн тайланг гаргаж, 20 хоногийн дотор ТАТБ-д хүргүүлнэ. [38.4. 59.]

Төсвийн хэрэгжилт

Засаг дарга Төсвийн хэрэгжилтийн төлөө хариуцлага хүлээнэ. [52. 53]

[...] Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн заалтуудыг ашиглав
ТАТБ - Төрийн Аудитийн Төв Байгууллага

Орон нутгийн төсвийн хяналт хэрхэн хэрэгжих вэ?

Аливаа удирдлагын үйл явцад хяналтыг дараах үе шатуудаар авч үздэг билээ. Энэ нь орон нутгийн төсөв дээр мөн адил юм. Төсвийн хяналт дараах үе шатуудыг дамжин явагдаж байдаг.

• :14

Хяналтын дэс дараалал



Хэрэв төсвийг хэрэгжүүлэх явцад түүнд гүйцэтгэлийн болон зарцуулалтын өөрчлөлт хийх бол түүнийг улирал бүр ИТХ-аар хэлэлцэн тогтдог. Ингээд ИТХ-ын зохих шийдвэрийн дагуу тухайн аймаг, сумын Засаг дарга төсвийг өөрчлөн зарцуулах эрх олж авдаг. Бусад улс оронд төсвийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлдэг талаар авч үзэхэд АНУ-ын Орегон мужийн төсвийн хяналт сонирхолтой санагдсаныг энд өгүүлье.

АНУ-ын Орегон мужийн төсвийн хяналт

Энэ муж улсын төсвийн хяналт нь орон нутгийн эрх баригчид, төрийн аудитийн байгууллага, орон нутгийн иргэдийн оролцоотой хэрэгждэг нь манай улстай адил боловч “Төсвийн Хороо” буюу Budget Committee гэдэг орон нутгийн төсвийн үйл явцыг хянах (сард 1-ээс доошгүй удаа хуралдана), зөвлөлгөө өгөх үүрэгтэй орон тооны бус бүтэц Захирагчийн дэргэд ажилладаг байна. Энэ хорооны гишүүд цалин авдаггүй.

Энд төсвийг шууд гардан хариуцдаггүй төрийн албан хаагчид, чөлөөт иргэд 50:50 бүрэлдэхүүнтэй байдаг ба орон нутгийн бүх иргэд, улс төрийн намууд, ТББ, бусад бүлгүүдийн төлөөллийг тэгш оролцуулна. Төсвийн Хорооны гишүүдийн 1/3 нь жил бүр дахин сонгогдох ёстой. Ингээд 3 жил тутам Төсвийн Хороо шинэчлэгддэг.

Төсвийн Хороо нь дараах үйл ажиллагаа явуулна.

1. Төсвийн талаархи мэдээллийг түгээж, иргэдийн төсвийн талаархи саналыг хүлээн авна.
2. Төсвийн үйл явцын үе шат бүрт албан бус дүгнэлт гаргаж, түүнийгээ Орон нутгийн захирагч болон орон нутгийн хуралд танилцуулна.
3. Орон нутгийн иргэд болон бусад талуудын саналыг төсвийн үйл явцад тусгах асуудлыг орон нутгийн хурлаар дамжуулан хэрэгжүүлнэ.

5.3

Иргэд орон нутгийн төсвийг хянахад хэрхэн оролцож байна вэ?

Иргэд орон нутгийн төсвийн үйл явцад хяналт тавих боломж сул байна. Энэ асуудал нь иргэдийн (олон нийтийн) хяналт хууль зүйн хүрээнд баталгаажуулахгүй байгаагаас гадна тэдэнд хангалттай мэдээлэл хүрдэггүй, түгээж буй мэдээлэл тэдний хэрэгцээг хангахгүй байгаатай холбоотой юм.

§ :10

Олон нийтийг мэдлэгээр хангах төрийн үүрэг

- ∅ Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний Аудитын Газар гүйцэтгэлийн аудитын болон бусад тайланг хэвлэн нийтлэх буюу бусад арга замаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээж болно.
- ∅ Үндэсний Аудитын Газар өөрийн хийсэн аудитын тайлангийн жагсаалтыг улирал тутам гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон цахим сүлжээгээр мэдээлнэ.

Монгол улсын Төрийн Аудитийн тухай хуулиас ашиглав.

ИТХ нь юуны өмнө төсвийн явцын хяналтыг зохистой хийх, түүнд иргэдийг татан оролцуулах боломжийг хангах ёстой. Гэтэл ИТХ ч өөрөө төсөвт явцын хяналт тавих боломж хязгаарлагдмал байгааг хэлэх ёстой. ИТХ-уудын олонхи нь улирал бүрт болдог хурлаараа төсвийн хэрэгжилт, зарцуулалтын асуудлыг сонсож, хэлэлцдэг боловч түүний явцад нөлөөлөх бодит боломж хомс ажээ. Харин төсвийн эцсийн хяналт ИТХ-аар дамжин хэрэгждэг. Энэ талаар сумынхаа нэг хүнээс асуухад ийн ярьж байлаа.

ê :10

Эрдэнэ сумын иргэн А-ийн ярианаас:

Бидэнд өөрийн сум, аймгийн төсөвтөө хяналт тавих боломж маш бага байгаа гэж би хувьдаа боддог. Мэдээж татвар төлөгч иргэн, харьяатын хувьд орон нутгийн төсвөө их сонирхдог. Гэвч энэ чиглэлийн мэдээлэл бага, сумын ЗДТГ-ын үүдэнд самбарт хааяа хаддаг төсвийн цөөн тоог сониуч над мэтийн хүмүүс л хардаг байх. Иймд бидэнд өргөн мэдээлэл хэрэгтэй байна.

Мэдээж, сум, аймгийн төсвийг тухайн шатны ИТХ хэлэлцэж, хянадаг болохыг мэднэ. Гэхдээ ИТХ-ын төлөөлөгчдөөр дамжуулан хяналт тавих боломж байгаа боловч бодит байдал дээр хэрэгждэггүй. Миний хувьд мэдээллийг ойлгомжтой, байнга иргэдэд хүргэдэг болох, бидний тавьсан саналыг хэрхэн хэлэлцэж шийдсэнийг мэдээлдэг байх, төлөөлөгч бүр иргэдтэй байнга холбоотой байх нь чухал гэж боддог.

Иргэдийн хувьд төсөвт явцын хяналт тавих албан ёсны ганц суваг нь ИТХ-ын төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжих ёстой. Гэвч бодит байдал дээр төсвийн зарцуулалтанд нөлөөлөх боломж хурлын төлөөлөгчид ч байхгүй байна. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-иар бол тухайн орон нутгийн юмуу төрийн байгууллагын төсөв батлагдсан бол түүний явцын хэрэгжилт, зарцуулалтыг тухайн төсвийн менежер бүрэн хариуцах учиртай.

Мэдээлэл бол хяналтын хамгийн эхний, нэн чухал урьдач нөхцөл юм. Мэдээлэлгүйгээр бид орон нутгийн төсвөө хянах боломж бүрдэхгүй.

Төсвийн цогц мэдээлэл гэж юу вэ?

ОХУ-ын Пенза мужид хэрэгжиж буй “Тунгалаг төсөв” (Прозрачный бюджет) төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Энэхүү төсөл нь орон нутгийн төсвийн үйл явцад иргэд, ТББ-уудыг оролцуулах арга замуудыг гарган тавих, төгөлдөржүүлэхэд чиглэгдэж байгаа ажээ. Энд дараах арга замуудыг маш ач холбогдолтой гэж онцолжээ.

п Төсвийн цогц мэдээлэл – Төсвийн төсөл болон дагалдах задаргаа, төсвийн тухай хуулиуд, орон нутгийн Тамгын газрын төсвийн бүрдэлт ба зарцуулалтын тухай мэдээлэл, төсөвтэй холбоотой журмууд болон эрх зүйн актуудыг нэгэн багц болгон орон нутгийн хурлууд юмуу ТББ-ын дэргэд мэдээллийн сан бүрдүүлж, түүнийг ашиглах бололцоог иргэдэд олгож эхэлсэн.

п Төсвийн хавсарга судалгаа ба шинжилгээ – Орон нутгийн төсвийг бүрдүүлэхээс эхлээд түүний тодорхой хэрэгжилт юмуу зарцуулалт нь хүн амын тодорхой бүлгийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар мини-илтгэлүүдийг бэлтгэн иргэд болон олон нийтэд түгээн санал авдаг болжээ.

Эх сурвалж:
www.transparentbudget.ru
вебсайтаас ашиглав.

U :5

Иргэд орон нутгийн төсвийн мэдээллийг

- Ø Тухайн шатны ЗДТГазрын төсвийн асуудал хариуцсан түшмэл
- Ø ИТХ-ын төлөөлөгч
- Ø Төрийн Аудитийн Алба
- Ø Орон нутгийн Төрийн Сангаас авч болно.

Эдгээр төрийн байгууллага болон зохих албан тушаалтнууд иргэдэд төсвийн мэдээллийг өгөх буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээх үүрэг хүлээдэг.

Орон нутгийн төсвийн үйл явцад оролцохын тулд зөвхөн мэдээлэл олж аваад зогсохгүй, түүнийгээ ашиглаж, төсвийн үйл явцад нөлөөлөх хэрэгтэй.

Иргэд төсвийн үйл явцыг хянах дараах сувгуудыг ашиглаж болно.



Ø ИТХ-ын төлөөлөгчид

Иргэдийн шууд төлөөллийн байгууллага учраас та ганцаараа шууд хандахад дөхөмтэй юм. Таны тавьсан санал, хүсэлтийг хүлээж авч, түүнийг төсөвт тусгуулах эрх зүйн боломжтой учир ИТХ-ын төлөөлөгч иргэний хувьд төсвийн үйл явцад оролцох “хамгийн эхний гүүр” байх болно.




Ø Засаг дарга болон төсвийн хяналтын асуудал хариуцсан түшмэлүүд

Төсвийн үйл явцын үндсэн хэрэгжүүлэгч тал боловч батлагдсан төсвийн хүрээнд л тэд үйл ажиллагаагаа явуулах учраас шууд иргэдээс тавьсан хүсэлтийг хэрэгжүүлэх боломж нь хомс юм.



Ø *Орон нутгийн төрийн бус байгууллагууд*

Төрийн бус байгууллагууд (ТББ) нь нийгмийн янз бүрийн бүлгүүд, ашиг сонирхлын төлөөлөл байдаг учраас иргэний нөлөөллийг төсвийн үйл явцад тусгах зохистой боломжийг агуулдаг. Мөн үүний хамт ТББ-д хандсанаар таны санал, оролцоо илүү олон хүний дэмжлэг авч, мэргэжлийн түвшинд боловсрогдон тавигдах боломж хангагдана.



Ø *Улс төрийн намууд*

Өнөөдөр орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчид улс төрийн намуудаас сонгогддог. Иймд ИТХ дахь намын бүлэгт юмуу гишүүдэд хандах нь өөрийн санал, нөлөөллийг шууд гарган тавих бололцоог иргэнд олгохын хамт томоохон дэмжлэг (хэрэв тухайн нам ИТХ-д олонхи бол) хүлээх боломжтой.



Ø *Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл*

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио, сонин зэрэг) нь шууд төсвийн үйл явцад нөлөөлөх боломжийг олгохгүй боловч өөрийн тавьж буй асуудал, хэрэгцээтэй оролцооны асуудлыг бусдад хүргэх, тухайн асуудлаар олон нийтийн дэмжлэгийг олж авах, хамтрагчидтай болох бололцоог танд олгоно.

Ингээд миний ойлгосноор хяналтын зэрэгцээгээр иргэд байнга оролцох, нөлөөлөх боломжийг бүрдүүлэх нь орон нутгийн төсөв нээлттэй, тунгалаг байх гол нөхцөл юм. Энэ талаар бид дараагийн бүлэгт ярилцана.

6. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭД ХЭРХЭН ОРОЛЦОЖ БАЙГАА ВЭ?

?:4



Орон нутгийн төсвийн үйл явцад иргэдийн оролцоо нэн чухал гэдгийг хүн бүр дэмждэг.

Гэсэн хэдий ч өнөөдөр орон нутгийн төсөвт иргэдийн оролцоо хамгийн доогуур түвшинд байна. Орон нутгийн төсвийн талаар багийн болон сум, дүүргийн, аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч, Засаг дарга нар мэдээлэл хийдэг боловч энэ нь иргэдэд тийм ч их хүртээлтэй биш хэвээр байгаа юм.

Орон нутгийн иргэдээс төсвийн талаар асуухад төсөвт байгууллагад ажиллагсадаас бусад нь төсвийн талаар мэдлэг, мэдээллээр хомс байдаг. Одоохондоо, иргэд дараахь байдлаар төсвийн үйл явцад оролцох боломж нээлттэй гэдгийг би олж мэдсэн.

Иргэдийн оролцооны өнөөгийн хэлбэрүүд

• :15

Орон нутгийн төсөвтэй уялдаатайгаар

1. Тухайн оны улсын нэгдсэн төсөв баталсны дараа орон нутгийн төсвийн талаар тухайн оны ерөнхий мэдээлэл, түүний чиглэлийн талаархи төсөөллийг авч болно.



2. Өөрийн ажилладаг байгууллага болон орон нутагт ямар ажлыг хийх талаар саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавина.



3. Таны санал дэмжигдвэл орон нутгийн төсвийн төсөлд сууж өгнө.

Дээд шатны төсөвтэй уялдаатайгаар

1. Тухайн оны Улсын Нэгдсэн Төсөв хэлэлцэн батлах үед өөрийн орон нутгийн төсөвтэй холбоотой асуудлаар өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнээр дамжуулан саналаа уламжилж болно.



2. Өөрийн ажилдаг байгууллага, орон нутгийн төсөвтэй холбоотой асуудлаа Засаг дарга болон ИТХ-ын төлөөлөгчдөд тавьж, орон нутгийн төсөв хэлэлцэхэд оролцож болно.



3. Нэгэнт таны санал дэмжигдэхгүй бол дараа жилийн төсөвт оруулах л боломж үлдэнэ.


Хэдийгээр оролцооны ийм арга замууд байгаа ч иргэдийн зохион байгуулалттай, идэвхитэй хэлбэр болж чадахгүй байгаа юм. Иймд төсвийн үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх боломжийг дараагийн хэсэгт авч үзэцгээе.

Төсвийн үйл явцад иргэд оролцоогоо хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Юуны өмнө төсвийн үйл явцын шат бүрт иргэдийн оролцоог жигд өргөтгөх, түүний эрх зүйн баталгааг бий болгох асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байгаа юм. Үүнийг хийхийн тулд дараах асуудал нэн чухал юм.¹

¹ Улс төрийн Боловсролын Академиас орон нутгийн иргэд, төрийн байгууллагын ажилтнуудаас орон нутгийн төсвийн талаар судалгаа авч, ярилцахад эдгээр асуудлуудыг хамгийн ихээр хөндөн тавьж байсныг энд ашиглав.

• :16



Би хувьдаа иргэдийн орон нутгийн төсвийн үйл явцад оролцох гол суваг нь ИТХ гэж боддог ч чухам ямар оролцоотой байх нь тодорхой бус байдаг. Зөвхөн ИТХ-ын хуралдаанд ажиглагчийн үүрэгтэй суух нь хангалттай биш гэж бодож байна. Иймд цаашдаа өргөн хэрэглэж болохоор ОХУ-ын нэгэн мужийн туршлагаас товч хуваалцаж.¹

ОХУ-ын Пенза мужид хэрэгжиж буй “Тунгалаг төсөв” төслийн хүрээнд иргэдийн оролцооны хэлбэрүүд, түүний арга замуудыг боловсронгуй болгох, тогтмолжуулах талаар дараах арга замуудыг хэрэглэж байгаа ажээ.

I. Төсвийн олон нийтийн сонсгол байнга хийдэг (Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр).

II. Төсвийн үйл явцын талаархи улс төрчид, иргэд, ТББ-ууд оролцсон зөвлөлдөх уулзалтуудыг тогтмол зохиодог болсон.

III. Төсвийн лоббийн¹ үйл явцад иргэд, ТББ-ууд болон улс төрчид хамтран оролцдог.

IV. Төсвийн хавсарга судалгааны хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлагад иргэд, ТББ-ууд, улс төрчид, судлаачид болон бусад сонирхогч талууд хамтран оролцдог болжээ.

¹ Төсвийн лобби – Иргэд, ТББ-ууд өөрийн санал, санаачлагаа ИТХ-ын төлөөлөгчөөр дэмжүүлэн төсөвт оруулах үйл явц юм.

Бидний ярилцсан аргуудыг манайд ч хэрэглэж эхэлсэн; Тухайлбал, Дархан-Уул аймгийн ИТХ өөрийн нээлттэй хуралдааныг аймгийнхаа “Залуучууд” театрт зохион байгуулж, бүх сонирхогч талыг оролцуулан нээлттэй хэлэлцүүлэг явуулсан болохыг би сонссон. Гэвч энэ нь өргөн хүрээнд тархаж чадаагүй байгаа билээ.

U:6

Миний ойлгосноор бол иргэдийн оролцооны олон аргууд байж болох ба тэдгээрийг хэрхэн ашиглаж, өөрийн оролцоог зохистой хэрэгжүүлэх нь тухайн орон нутгийн иргэд, ИТХ, Засаг дарга болон ТББ-ын хамтын ажиллагаанаас л хамаарна. Ингэхдээ тухайн иргэний хувьд өөрийн оролцоог хэрэгжүүлж, төсөвт нөлөөлөхийн тулд бусдын туслалцааг авч, өөрийн нөлөөллийг дээшлүүлж болно. Энд би Германы Нюртинген хотын туршлагаас товч өгүүлье.

ê :13

Нюртинген хотын иргэд “Идэвхтэй байгаль хамгаалал” төслийн хүрээнд өөрийн хотын төсөвтөө үйлдвэрийн хорооллын агаарын бохирдлыг багасгах зардлыг тусгуулахдаа дараах бүтэцтэй ажиллажээ.

- Ø Тухайн асуудлын байгаль орчны үнэлгээг байгалийн шинжлэлийн асуудлаар суралцдаг оюутнууд өөрсдийн судалгааны хүрээнд;
- Ø Судалгааны ажиглалтын асуудлыг өндөр настнууд;
- Ø Түүний эрх зүйн асуудлуудыг ТББ-ын ажилтнууд болон сайн дурын үндсэн дээр туслалцаа үзүүлсэн хуульчид;
- Ø Орон нутгийн хэмжээнд асуудлыг сурталчлах, төсвийн хэлэлцүүлэгт асуудлыг тусгуулах мэдээллийн ажлыг ТББ-ын ажилтнууд болон сэтгүүлчид;
- Ø Тухайн асуудлыг төсвийн зардлын хэлэлцүүлэгт багтаах асуудлыг орон нутгийн хурлын төлөөлөгчдийн төлөөлөл хариуцан ажиллажээ.

Эдгээр бүлгүүдийн дийлэнх нь үнэ хөлсгүйгээр сайн дурын үндсэн дээр тухайн төсвийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулсан боловч бүгд ямар нэг хэмжээгээр тухайн асуудалд хамааралтай, хамгийн гол нь өөрсдийн оролцоог бүрэн хэрэгжүүлэх чадавхитай байсан нь хамгийн чухал юм.

Энэ бүхний эцэст дүгнэн хэлэхэд хэдийгээр Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд иргэдийн оролцооны талаар тусгайлан заасан зүйл байхгүй, төсвийн практикт иргэдийн оролцооны хэлбэрүүд хэлбэржин тогтож чадаагүй ч иргэд өөрсдөө өөрсдийн хүчин чармайлтаар орон нутагтаа үүнийг бий болгож чадна гэж би боддог. Иргэд зөвхөн төсөв санхүүгийн асуудлын хувьд төдий бус орон нутагт болон нийгэмд нийтлэг ач холбогдолтой ямарваа асуудалд оролцож байж гэмээнэ ард түмний засаглал жинхэнэ утгаараа хэрэгжих учиртай. Ардчилсан иргэний нийгмийн гол хөдөлгөгч хүч бол идэвхитэй оролцоо бүхий иргэд билээ.

Миний та бүхэнд танилцуулсан, зөвлөсөн эдгээр асуудлууд хэдийгээр бүрэн дүүрэн биш ч гэлээ орон нутгийн төсвийн үйл явцыг боловсронгуй болгох буюу иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар иргэний ардчилсан нийгэм хөгжин бэхжихэд өчүүхэн ч гэлээ тус нэмэр болно гэж найдаж байна. Мөн www.forum.mn сайтаас орон нутгийн төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Та бүхэнд амжилт хүсье.